

2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/Төгрөгөөр/			
Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	158,910,422.73	163,194,648.98
35	БАРАА МАТЕРИАЛ		
351	Түүхий эд материал	158,910,422.73	163,194,648.98
35130	Эм боох материал	4,192,000.00	2,124,500.00
354	Хангамжийн материал	4,192,000.00	2,124,500.00
35420	Аж ахуйн материал	154,718,422.73	161,070,148.98
35470	Бусад хангамжийн материал	20,830,553.60	18,789,410.60
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	2,713,779,363.87	2,863,714,896.21
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ		
392	Биет хөрөнгө	2,713,779,363.87	2,863,714,896.21
39201	Барилга, байгууламж, орон сууц	2,266,229,363.87	2,415,239,896.21
39202	Хуримтлагдсан элэгдэл	2,100,329,204.00	2,100,329,204.00
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	-98,497,816.32	-178,066,280.60
39206	Хуримтлагдсан элэгдэл	361,184,404.54	369,087,242.38
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	-259,307,664.84	-87,217,314.58
39208	Хуримтлагдсан элэгдэл	97,272,670.51	126,727,633.50
39213	Түүх соёл, музейн дурсгалт зүйлс	-64,520,233.22	-32,950,088.13
39214	Бусад үндсэн хөрөнгө	15,000,000.00	15,000,000.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	55,109,036.00	51,309,036.00
39217	Ном	-13,787,744.39	-15,138,880.19
393	Биет бус хөрөнгө	73,447,507.59	66,159,343.83
39301	Програм хангамж	447,550,000.00	448,475,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	1,087,000.00	925,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	2,872,689,786.60	3,026,909,545.19
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	2,872,469,786.60	3,026,909,545.19
51	Засгийн газрын хувь оролцоо	2,872,469,786.60	3,026,909,545.19
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан		
		1,211,897,505.67	1,211,897,505.67
51101	Өмч: - төрийн	1,211,897,505.67	1,211,897,505.67
512	Хуримтлагдсан үр дүн	1,212,857,648.52	1,370,891,799.90
51210	Өмнөх үеийн үр дүн	1,212,857,648.52	1,216,452,041.31
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	154,439,758.59
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	447,714,632.41	444,120,239.62
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	2,872,689,786.60	3,026,909,545.19

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/Төгрөгөөр/			
Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	2,032,721,446.03	2,298,873,971.05
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,825,285,546.03	1,973,988,724.05
120	Нийтлэг татварын бус орлого	636,606,546.03	272,884,724.05
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	636,606,546.03	263,625,118.80

Хөвсгөл аймгийн Титэм ерөнхий боловсролын сургуулийн
2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

123	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг		
123001	Тусгай зориулалтын шилжүүлгийн орлого	1,188,679,000.00	1,701,104,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	207,435,900.00	324,885,247.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	5,269,100.00	15,045,247.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.00	1,050,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.00	13,925,247.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	5,269,100.00	70,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	202,166,800.00	309,840,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	202,166,800.00	309,840,000.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,385,546,847.05	2,129,136,780.46
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,385,546,847.05	2,129,136,780.46
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,373,119,647.05	2,053,705,934.62
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	987,601,258.00	1,394,575,642.00
210101	Үндсэн цалин	987,601,258.00	1,171,700,146.00
210102	Нэмэгдэл	00.00	149,576,793.00
210104	Урамшуулал	00.00	73,298,703.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	123,611,198.00	183,216,629.62
210201	Тэтгэврийн даатгал	84,515,942.00	127,789,559.32
210202	Тэтгэмжийн даатгал	10,045,041.00	14,362,182.35
210203	ҮОМШӨ-ний даатгал	7,921,795.00	11,229,792.63
210204	Ажилгүйдлийн даатгал	1,920,765.00	2,712,281.35
210205	Эрүүл мэндийн даатгал	19,207,655.00	27,122,813.97
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	172,902,331.00	297,796,224.54
210301	Гэрэл, цахилгаан	3,235,065.00	4,350,554.00
210302	Түлш, халаалт	167,274,100.00	286,755,628.09
210303	Цэвэр, бохир ус	2,393,166.00	6,690,042.45
2104	Хангамж, бараа материалын зардал	6,134,437.00	15,269,202.00
210401	Бичиг хэрэг	109,240.00	2,269,120.00
210402	Тээвэр, шатахуун	80,000.00	263,952.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	895,157.00	2,339,917.00
210404	Ном, хэвлэл	150,000.00	136,200.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,798,000.00	2,055,760.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,102,040.00	8,204,253.00
2105	Нормативт зардал	765,355.00	2,259,630.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	765,355.00	2,259,630.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,993,000.00	11,713,880.00
210604	Урсгал засвар	3,993,000.00	11,713,880.00
2107	Томилолт, зочны зардал	00.00	1,243,250.00
210702	Дотоод албан томилолт	00.00	1,243,250.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	555,500.00	3,825,307.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	385,500.00	2,817,307.00

Хөвсгөл аймгийн Титэм ерөнхий боловсролын сургуулийн
2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	170,000.00	1,008,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	77,556,568.05	143,806,169.46
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	00.00	19,742,916.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	77,556,568.05	124,063,253.46
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	12,427,200.00	75,430,845.84
2132	Бусад урсгал шилжүүлэг	12,427,200.00	61,922,100.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	11,797,200.00	61,622,100.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	630,000.00	300,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	00.00	139,895.46
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	139,895.46
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	00.00	13,368,850.38
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	13,368,850.38
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	647,174,598.98	169,737,190.59
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	00.00	15,297,432.00
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	00.00	15,297,432.00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	00.00	-15,297,432.00
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	647,174,598.98	154,439,758.59

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/ төгрөгөөр /

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,211,897,505.67	447,714,632.41	1,212,857,648.52	2,872,469,786.60
2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,211,897,505.67	447,714,632.41	1,212,857,648.52	2,872,469,786.60
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	3,594,392.79	3,594,392.79
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,211,897,505.67	447,714,632.41	1,216,452,041.31	2,876,064,179.39
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	-3,594,392.79	00.00	-3,594,392.79
Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	154,439,758.59	154,439,758.59
2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,211,897,505.67	444,120,239.62	1,370,891,799.90	3,026,909,545.19

Хөвсгөл аймгийн Титэм ерөнхий боловсролын сургуулийн
2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/Төгрөгөөр/			
Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	2,074,530,200.00	2,031,602,247.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,742,661,800.00	1,701,104,000.00
122002	Хандив тусламж /гадаад/		
123	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	1,742,091,800.00	1,701,104,000.00
123001	Тусгай зориулалтын шилжүүлгийн орлого	1,742,091,800.00	1,701,104,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	331,868,400.00	330,498,247.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	8,022,100.00	20,658,247.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.00	1,050,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.00	13,925,247.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	8,022,100.00	5,683,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	323,846,300.00	309,840,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	323,846,300.00	309,840,000.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	2,024,269,285.31	2,005,931,148.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,024,269,285.31	2,005,931,148.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,908,896,429.46	1,930,500,302.16
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,359,119,353.00	1,394,575,642.00
210101	Үндсэн цалин	1,093,580,572.51	952,140,577.58
210102	Нэмэгдэл	157,683,426.02	369,136,361.42
210104	Урамшуулал	107,855,354.47	73,298,703.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	170,635,826.46	183,216,629.62
210201	Тэтгэврийн даатгал	118,871,122.94	128,722,593.54
210202	Тэтгэмжийн даатгал	12,979,634.54	13,653,258.85
210203	ҮОМШӨ-ний даатгал	9,432,825.43	10,925,325.89
210204	Ажилгүйдлийн даатгал	2,681,328.55	3,095,212.00
210205	Эрүүл мэндийн даатгал	26,670,915.00	26,820,239.34
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	296,552,536.00	297,796,224.54
210301	Гэрэл, цахилгаан	4,922,420.00	4,350,554.00
210302	Түлш, халаалт	277,794,637.00	286,755,628.09
210303	Цэвэр, бохир ус	13,835,479.00	6,690,042.45
2104	Хангамж, бараа материалын зардал	30,092,323.00	16,278,539.00
210401	Бичиг хэрэг	1,144,140.00	2,269,120.00
210402	Тээвэр, шатахуун	377,000.00	263,952.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,629,943.00	2,339,917.00
210404	Ном, хэвлэл	8,004,800.00	5,749,200.00

Хөвсгөл аймгийн Титэм ерөнхий боловсролын сургуулийн
2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	3,339,000.00	2,055,760.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	15,597,440.00	3,600,590.00
2105	Нормативт зардал	6,393,865.00	1,326,330.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	5,277,365.00	726,330.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,116,500.00	600,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	8,350,426.00	11,903,880.00
210604	Урсгал засвар	8,350,426.00	11,903,880.00
2107	Томилолт, зочны зардал	00.00	1,243,250.00
210702	Дотоод албан томилолт	00.00	1,243,250.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,390,700.00	4,545,307.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	620,700.00	3,537,307.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	770,000.00	1,008,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	36,361,400.00	19,614,500.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	36,361,400.00	19,614,500.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	115,372,855.85	75,430,845.84
2132	Бусад урсгал шилжүүлэг	40,154,100.00	61,922,100.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	37,733,400.00	61,622,100.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,420,700.00	300,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	19,582,464.00	139,895.46
213402	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт сумдад		
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	19,582,464.00	139,895.46
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	55,636,291.85	13,368,850.38
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	55,636,291.85	13,368,850.38
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	50,260,914.69	25,671,099.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	50,260,914.00	25,671,099.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	50,260,914.00	25,671,099.00
2200	Дотоод эх үүсвэрээр	50,260,914.00	25,671,099.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	50,260,914.00	25,671,099.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-50,260,914.00	-25,671,099.00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	0.00	0.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	0.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	0.00

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/ төгрөгөөр /

Хөвсгөл аймгийн Титэм ерөнхий боловсролын сургуулийн
2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,010,944,000.00	1,997,435,254.16
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,010,944,000.00	1,997,435,254.16
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,948,911,900.00	1,935,513,154.16
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,398,732,800.00	1,394,575,642.00
210101	Үндсэн цалин	919,215,800.00	952,140,577.58
210102	Нэмэгдэл	406,117,000.00	369,136,361.42
210104	Урамшуулал	73,400,000.00	73,298,703.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	188,829,000.00	183,216,629.62
210201	Тэтгэврийн даатгал	132,879,600.00	128,722,593.54
210202	Тэтгэмжийн даатгал	13,987,300.00	13,653,258.85
210203	ҮОМШӨ-ний даатгал	11,189,900.00	10,925,325.89
210204	Ажилгүйдлийн даатгал	2,797,500.00	3,095,212.00
210205	Эрүүл мэндийн даатгал	27,974,700.00	26,820,239.34
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	297,927,300.00	297,796,224.54
210301	Гэрэл, цахилгаан	4,400,000.00	4,350,554.00
210302	Түлш, халаалт	286,827,300.00	286,755,628.09
210303	Цэвэр, бохир ус	6,700,000.00	6,690,042.45
2104	Хангамж, бараа материалын зардал	11,433,400.00	9,970,592.00
210401	Бичиг хэрэг	1,027,300.00	1,159,200.00
210402	Тээвэр, шатахуун	500,000.00	333,952.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,427,300.00	2,339,917.00
210404	Ном, хэвлэл	1,189,400.00	1,066,500.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,713,600.00	1,470,433.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,575,800.00	3,600,590.00
2105	Нормативт зардал	1,387,800.00	1,326,330.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	775,600.00	726,330.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	612,200.00	600,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	25,645,200.00	25,226,679.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	2,500,000.00	2,432,799.00
210602	Тавилга	11,232,500.00	10,890,000.00
210604	Урсгал засвар	11,912,700.00	11,903,880.00
2107	Томилот, зочны зардал	1,840,900.00	1,243,250.00
210702	Дотоод албан томилот	1,840,900.00	1,243,250.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,600,500.00	2,543,307.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,592,500.00	1,535,307.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,008,000.00	1,008,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	20515000.00	19614500.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	20,515,000.00	19,614,500.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	62,032,100.00	61,922,100.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	61,622,100.00	61,622,100.00

Хөвсгөл аймгийн Титэм ерөнхий боловсролын сургуулийн
2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	410,000.00	300,000.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	2,010,944,000.00	1,997,435,254.16
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,701,104,000.00	1,687,735,149.62
131001	Улсын төсвөөс санхүүжих	00.00	00.00
131006	Засгийн газрын тусгай сангаас санхүүжих	00.00	00.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	1,701,104,000.00	1,687,735,149.62
131008	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас санхүүжих	00.00	00.00
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	309,840,000.00	309,700,104.54
132001	Орон нутгийн төсвөөс	309,840,000.00	309,700,104.54
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	105.00	108
620001	Удирдах ажилтан	01.00	01
620002	Гүйцэтгэх ажилтан	85.00	89
620003	Үйлчлэх ажилтан	19.00	18
63	СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР)	1,844.00	1,899
630	ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬД СУРАЛЦАГЧИД	1,844.00	1,899
630001	Төрийн өмчит ЕБС	1,844.00	1,899

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/ төгрөгөөр /

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	20,658,247.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	20,658,247.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	20,658,247.00
2104	Хангамж, бараа материалын зардал	7,308,247.00
210401	Бичиг хэрэг	1,109,920.00
210404	Ном, хэвлэл	5,613,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	585,327.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	10,600,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	10,600,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2750000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,750,000.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	20658247.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	20,658,247.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,050,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	13,925,247.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	5,683,000.00

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана." гэж заасны дагуу Хөвсгөл аймгийн Титэм ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд шилэн данс, орон тоо цалингийн зардлын данстай холбоотой өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Бизкон Аудит ХХК-ийн ахлах аудитор Ч.Мөнхбаяр, туслах аудитор Б.Түмэндэмбэрэл нар гүйцэтгэж, хяналтыг Бизкон аудит ХХК-ийн захирал Л.Отгонбаяр, Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Г.Эрдэнэчимэг аудитын менежер Э.Бат-Эрдэнэ, газрын дарга, тэргүүлэх аудитор А.Эрдэнэбаатар нар тус тус хэрэгжүүлсэн.

Хөвсгөл аймгийн Титэм ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Бизкон аудит компанийн Хөвсгөл аймаг дахь салбарт 2022 оны 01 дүгээр сарын 24-ны өдрийн 1/90 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Хөвсгөл аймгийн Титэм ерөнхий боловсролын сургууль нь бага, дунд боловсролын үйл ажиллагаа явуулдаг Хөвсгөл аймгийн Мөрөн сумын засаг даргын харьяа байгууллага юм.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Хөвсгөл аймгийн засаг даргын 2019 оны 09 дүгээр сарын 04-ий өдрийн А/375 захирамжаар баталсан нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг тус байгууллага нь мөрдөж байгаа бөгөөд холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолоор баталсан "Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам"-д заасны дагуу Хөвсгөл аймгийн Титэм ерөнхий боловсролын сургууль 2020 оны Б/18 тоот тушаалаар дотоод хяналт шалгалтын зөвлөлийн нэгж ажилтныг таван хүний бүрэлдэхүүнтэй баталсан байна. Тайлант онд дөрвөн ажил гүйцэтгэхээр төлөвлөгөө батлуулан ажиллаж дотоод хяналтыг хангалттай хэрэгжүүлсэн байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудиторос шууд тусалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр

Аудитын код ХӨА-2022/229/НА-СТА-ТШЗ

Хөвсгөл аймгийн Титэм ерөнхий боловсролын сургуулийн
2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Хөвсгөл аймгийн Титэм ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг акрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл бага гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны үр дүнгийн тайлангийн нийт зардлын 2,095.5 сая төгрөгөөс 2.0 хувиар буюу 41.9 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 33.5 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж төлөвлөлтийн шатанд суурь үзүүлэлтийг өмнөх оны санхүүгийн тайлангийн дүнг ашигласан тул гүйцэтгэлийн шатанд материаллаг байдлыг шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Хөвсгөл аймгийн Титэм ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 154.3 сая төгрөгөөр буюу 5.3 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан нь үндсэн хөрөнгө, бараа материалын дансууд байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	00	00	00
Авлага	00	00	00
Урьдчилгаа	00	00	00
Бараа материал	158.9	163.2	4.3
Үндсэн хөрөнгө	2713.7	2863.7	150.0
Нийт хөрөнгө	2,872.6	3,026.9	154.3
Өр төлбөр	00	00	00
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	2,872.6	3,026.9	154.3
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	2,872.6	3,026.9	154.3

БШУЯамны сурах бичиг 7.0 сая төгрөгийн ном, Хими,физикийн лабораторийн 3.9 сая төгрөгийн техник хэрэгслийг Интер Сайнс ХХК ,Багш хөгжлийн төвийн техник хэрэгсэл тавилга 25.6 сая төгрөгийн хөрөнгүүдийг Саммит компьютер технологи ХХК, Тэргүүн Сонголт ХХК ,Эцэг эхчүүдийн хандиваар 98 ширхэг ширээ сандал 14.1 сая төгрөгийг Үндсэн хөрөнгөнд, Ариутгалын бодис, химийн лабораторийн бодис, багц 1,2,3 сургалтын хэрэглэгдэхүүн 6.4 сая төгрөгийг БШУЯамнаас түргэвчилсэн оношлуур 225 ширхэг, бээлий, хамгаалалтын хувцас 2.8 сая төгрөгөөр аймгийн Засаг даргын нөөцөөс нийлүүлсэн хөрөнгийг бүртгэж тайлагнасан. Хөвсгөл аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2021 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн “Үндсэн хөрөнгө худалдах, актлах, шилжүүлэх тухай” 109 дүгээр тогтоол, Хөвсгөл аймгийн Орон нутгийн өмчийн газрын 2021 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн 1/1267 албан бичиг, Мөрөн сумын ИТХ-ын тэргүүлэгчдийн 202 оны 39 дүгээр тогтоол

Хөвсгөл аймгийн Титэм ерөнхий боловсролын сургуулийн
2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

зэргийг үндэслэн сургалтын шаардлага хангахгүй үндсэн хөрөнгө, бараа материалыг данснаас хасч актласан байна.

Мөрөн сумын ИТХ-ын тэргүүлэгчдийн 202 оны 39 дүгээр тогтоолын 06 дугаар хавсралтаар тоног төхөөрөмж 173.3 сая төгрөг, тавилга хэрэгсэл 34.1 сая төгрөг, программ хангамжийн 1.1 сая төгрөгийн нийт 208,5 сая хөрөнгөнд дахин үнэ тогтоож ашиглах хугацааг сунгасан байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллага нь 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 2,296.3 сая төгрөгөөр төлөвлөж санал хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн саналаас 467.4 сая төгрөгөөр бууруулж 1,828.9 сая төгрөгөөр 2021 оны төсвийг баталсан байна. Тус байгууллага нь тайлант онд шаардлагатай зардлуудад 2 удаа 182.0 сая төгрөгөөр төсвийг нэмэгдүүлсэн зохицуулалт, тодотголыг хийлгэж санхүүжүүлэх эх үүсвэрийг 2,010.9 сая төгрөг болгосон байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх үндсэн үйл ажиллагааны хүрээнд 2 хөтөлбөрийн 5 арга хэмжээг санхүүжүүлэхээр 1,828.9 сая төгрөгийн төсөв баталсан ба 1,518.1 сая төгрөгийг улсын төсвийн хөрөнгөөр, 309.8 сая төгрөгийг орон нутгийн төсвөөр, өөрийн орлого 1.0 сая төсвөөр санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр үндсэн үйл ажиллагааны хүрээнд улсын төсвөөс 1,687.7 сая төгрөгийн, орон нутгийн төсвөөс 309.7 сая төгрөгийн санхүүжилт, нийт 1,997.4 сая төгрөгийн эх үүсвэр бүрдүүлж хөрөнгийн болон урсгал үйл ажиллагааны зардалд зарцуулж, 13.5 сая төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,997.4 сая төгрөг буюу 99.3 хувьтай байгаа нь хангамж бараа материал 97.8 хувийн, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр зардал 97.8 хувийн гүйцэтгэлтэй байгаа нь гол нөлөө үзүүлсэн байна. Хөтөлбөр, арга хэмжээний зардлыг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт2. Төсвийн гүйцэтгэлийн тайлан /үндсэн/ /сая төгрөг/

№	2 хөтөлбөр, 5 арга хэмжээ	ТӨЛӨВЛӨГӨӨ	ГҮЙЦЭТГЭЛ	Зөрүү	Хувь
	ХӨТӨЛБӨР 71802	1,969.1	1,958.2	10.9	
1	80109-ТЗШ-ийн байгууллагуудын тогтмол зардал	309.8	309.7	0.14	99.9
2	80802-АЖИЛ ОЛГОГЧООС ОЛГОХ ТЭТГЭМЖ УРАМШУУЛАЛ	0.4	0.3	0.11	99.8
3	81801-ҮДИЙН ХӨТӨЛБӨР ЦАЙ	61.6	61.6	-	100
4	81834-БОЛОВСРОЛЫН СТАНДАРТ СУРГАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ	1310.1	1302.6	7.5	99.4
5	81835-СУРГАЛТЫН ХЭВИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ХАНГАХ	287.1	283.9	3.2	98.9

Хөвсгөл аймгийн Титэм ерөнхий боловсролын сургуулийн
2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

6	ХӨТӨЛБӨР 71807	41.8	39.2	2.6	41.8
7	81834-БОЛОВСРОЛЫН СТАНДАРТ СУРГАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ	41.8	39.2	2.6	93.7
	ДҮН	2010.9	1997.4	13.5	

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

2021 онд нэмэлт төсвийн дансаар нийтдээ 20.6 сая.төгрөгийн орлого орж зарлага гарсан бөгөөд 20.6 сая төгрөгийн нэмэлт орлогыг дараах зориулалтын дагуу зарцуулсан байна.

Хүснэгт 3. Төсвийн гүйцэтгэлийн тайлан /нэмэлт/ /сая төгрөг/

ҮЗҮҮЛЭЛТ	ГҮЙЦЭТГЭЛ	Дүн
I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	20.6	20.6
Хангамж, бараа материалын зардал	7.3	7.3
Эд хогшил худалдан авах, урсгал засвар		
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр	10.6	10.6
Бараа үйлчилгээний бусад зардал	2.75	2.75
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР, Нэмэлт санхүүжилтийн орлого	20.6	20.6
ЗГНХ, Засаг даргын нөөц хөрөнгө түүнтэй адилтгах ангилалдаагүй нөөц хөрөнгөөс зохих байгууллагын шийдвэрийн дагуу тухай төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1.05	1.05
Дээд шатны төсвийн захирагчаас төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	13.9	13.9
Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	5.7	5.7

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Байгууллагын өөрийн орлогын 2021 онд 1.0 сая төгрөгийн өөрийн орлого оруулахаар спорт заалны түрээсийн орлого төлөвлөсөн боловч БШУЯ сайдын тушаалаар спорт заалыг сургалтад ашиглахаас өөр зориулалтаар ашиглахгүй байх журам батлагдсанаар Мөрөн сумын ИТХ-аар санал оруулан төсвөө хасуулсан байна. 2020 оны 12 дугаар сарын 18-ны өдөр Мөрөн сумын ИТХ-ын хуралдаанаар 2021 оны төсвийг 1,828.9 сая төгрөгөөр баталсан бөгөөд аймгийн ИТХ-ын хуралдааны 2021 оны 08 дугаар сарын 20-ны өдрийн 01 дүгээр тогтоолоор төсвийг 1,986.8 сая төгрөг болгож 157.9 сая төгрөгөөр нэмэгдүүлж тодотгол хийсэн бол аймгийн засаг даргын 2021 оны 12 дугаар сарын 07-ны өдрийн А/608 тоот захирамжаар 2,010.9 сая төгрөг болгож 24.1 сая төгрөг бүгд 182.0 сая төгрөгөөр нэмэгдүүлсэн байна. Энэ нэмэгдлээр цалин, нийгмийн даатгалын шимтгэл 222.2 сая төгрөг,

эд хогшил урсгал засварын зардал 31.1 сая төгрөг, эмийн зардал 0.4 сая төгрөгөөр тус тус нэмэгдсэн, байр ашиглахтай холбоотой зардал 11.9 сая төгрөг, үдийн хоолны зардал 54.0 сая төгрөгөөр, томилолтын зардал 0.3 сая төгрөгөөр хасагдсан байна. Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолд зааснаар цалин, нийгмийн даатгалын шимтгэлээс бусад зардлаас 23.7 сая төгрөгийн хэмнэлт гэргаагүй байна.

3.8 Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал байхгүй байна. Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт орсон өөрчлөлт байхгүй байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна. Бидний хувьд зөвхөн санхүүгийн тайлангийн аудит хийж гүйцэтгэсэн болно.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой асуудал

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант онд шилэн дансанд 151 мэдээлэл оруулах ёстойгоос 145 мэдээллийг цаг хугацаанд нь байршуулж, 1 мэдээллийн хугацаа хоцорсон, 5 мэдээллийг байршуулах хугацаа болоогүй байна. Цаашид шилэн данс сайтад байршуулж байгаа мэдээллийн үнэн зөв, чанар стандартад анхаарах шаардлагатай болсон байна. Шилэн дансан дахь мэдээлэл жирийн хэрэглэгч бүхэнд ойлгомжтой, тодорхой байх шаардлагатай байна.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн Засгийн газрын хувь оролцоо дансны санхүүгийн тайлан дахь үлдэгдэл 1,211.9 сая төгрөг байхад улсын бүртгэлийн гэрчилгээнд 386.9 сая төгрөг байгаа нь Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 10.3-д “Энэ хуульд өөрөөр заагаагүй бол энэ хуулийн 10.1-д заасан мэдээлэлд өөрчлөлт оруулах тухай шийдвэр, бусад баримт бичгийг тухайн хуулийн этгээд ажлын 15 өдрийн дотор улсын бүртгэлийн байгууллагад хүргүүлнэ” гэсэн заалттай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн хүрээнд 459.5 сая төгрөгийн 14 төрлийн худалдан авалтыг худалдан авалтын зохих журамд зааснаар зохион байгуулсан байна.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар төрийн аудитын байгууллагаас хүргүүлсэн 1 зөвлөмжийг хэрэгжүүлэн ажилласан байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Байгууллагын үйл ажиллагааны орлого, зардлын төлөвлөгөөг боловсруулахдаа үндэслэлтэй, төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангасан байх, хариуцлагатай байх зарчмуудыг мөрдөж тухайн үед Засгийн газраас гаргасан бодлого журамтай уялдуулан ажиллах шаардлагатай гэж үзлээ.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 39.0 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс, 23.7 сая төгрөгийн зөрчил арилгах албан шаардлага, орон тоо цалингийн сан, Шилэн дансны хуулийн хэрэгжилтээр 2 зөвлөмж өгсөн бөгөөд залруулсан алдаа, зөрчилтэй зүйл байхгүй болно.

4.1 Албан шаардлага

Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолд зааснаар Хөвсгөл аймгийн Титэм ерөнхий боловсролын сургууль нь цалин, нийгмийн даатгалын шимтгэл, төрөөс олгох дэмжлэгээс бусад тэвчиж болох зардлаас 10-аас доошгүй хувийн хэмнэлт буюу 23.7 сая төгрөгийг хэмнээгүй байх тул албан шаардлага өгсөн болно.

4.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Шилэн данстай холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

Шилэн дансны тухай хуулийн дагуу мэдээлэл байршуулсан дүнг хянаж үзэхэд нийт хугацаа хоцорсон 1 мэдээлэл байна. Мөн байршуулсан мэдээллийн чанар стандарт хангалтгүй байна. Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1:2 мэдээлэл ойлгомжтой, ач холбогдолтой байх, 6 дугаар зүйлийн 6.4-д "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ" гэсэн заалттай нийцэхгүй байна.

1.2. Өгсөн зөвлөмж:

Хуулийн хугацаанд шилэн дансны мэдээллийг үнэн зөв чанар стандартад нийцүүлж мэдээлэх

2. Орон тоо, цалинтай холбоотой асуудал

2.1. Илрүүлэлт:

Шинээр чиг үүрэг, албан тушаал бий болгож 3 багшийг батлагдсан орон тооноос илүү ажиллуулан 15.3 сая төгрөгийн зардлыг цалингийн сандаа багтаан гаргасан байна. Энэ нь Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын "Шинээр ажлын чиг үүрэг, албан тушаал бий болгохгүй, орон тоог нэмэгдүүлэхгүй байх" гэсэн заалттай нийцэхгүй байна.

2.2. Өгсөн зөвлөмж:

Батлагдсан төсөв, орон тооны хүрээнд ажил үйлчилгээг явуулах

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2022 оны 08 дугаар сарын 20-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

ХЯНАСАН:

АУДИТЫН МЕНЕЖЕР:

АХЛАХ АУДИТОР

БИЗКОН АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ

БОЛОВСРУУЛСАН:

БИЗКОН АУДИТ ХХК-ЫН АУДИТОР / Ч.МӨНХБАЯР/

АУДИТЫН ТАЙЛАНГ:

Огноо

/Э.БАТ-ЭРДЭНЭ/

Огноо

/Г.ЭРДЭНЭЧИМЭГ/

Огноо

/Л.ОТГОНБАЯР/

Хөвсгөл аймгийн Титэм ерөнхий боловсролын сургуулийн
 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

д/ д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Хөвсгөл аймгийн Титэм ерөнхий боловсролын сургууль	3	39.0	0	0.0	0	0	1	23.7	2	15.3